

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 07/280

НШУС

2007

ЦЕНЗУРЫН ҮҮСЭЛ, МӨН ЧАНАР

Ч.Чойсамба*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхмийн багш, доктор (Ph.D.), МУИС-ийн дэд профессор

Түлхүүр үг: цензур буюу хэвлэлийн хяналт, урьдчилсан цензур, цээрлүүлэх цензур, цензурын хэлбэрүүд.

Tүүхийн бүхий л үед хүн төрөлхтөнд ямар нэг зүйл мэдэхэд нь саад учруулж, хориг тавьж, цагдан хянасаар ирсэн билээ. Энэхүү цагдан хяналтыг гол төлөв эрх мэдэлтнүүд, цэрэг-улс төрийн хүчнийхэн, шашны байгууллагууд хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, цагдан хяналт буюу цензур (латини *cenzura* үгээс гаралтай) бол дээрээс доошоо чиглэсэн захиргаадалтын шинжтэй, хүний мэдэх эрхийг ноцтойгоор зөрчиж буй харгис, бурангуй агуулгатай арга хэмжээ юм.

Албан ёсны түүхэн эх сурвалжуудад тэмдэглэгдсэн, цензурыг хэрэглэсэн хамгийн анхны тохиолдол ХТӨ 605 онд гарчээ. Иудейн хаан Иоаким зөнч Иеремиягийн ном судруудыг шатаах зарлиг буулгасан байна. Энэ лүндэн гагцхүү цензурын төдийгүй, өөрийн цензурын

эхлэлийг нэг зэрэг тавьсан гэж судлаачид үздэг. Учир нь тэр явдлаас хойш өөрсдийн бүтээлээ Иеремиягийн адил шатаалгахгүйн тулд шажны зохиолчид бичиж буй зүйлээ хянах болжээ. Улмаар тэд зарим санаагаа дэлгэрүүлэхгүй орхих, заримыг нь битүү утгаар илэрхийлэх зэрэг аргыг хэрэглэх болсон юм¹.

ХТӨ 443 онд цензурыг хэрэгжүүлэх, гардан гүйцэтгэх анхны албан ёсны байгууллага бий болжээ. Эртний Ромын хотын удирдлагын дэргэд цензор хэмээх албан тушаал бий болсон байна. Тухайн үед энэхүү нэр томъёо орчин үеийн утгаасаа арай өөр агуулгатай байжээ. Цензор нь хотын дүрэм журмыг иргэд хэрхэн биелүүлж буй, мөн тэд ёс сууртахуунгүй үйлдэл гаргаж буй эсэхийг хянах үүрэгтэй байв.

Тэр цагаас хойш эрх мэдэлтнүүд өөрсдийн байр сууриа хадгалахын тулд юу эсийг хянаж цагдаж, хориглож, цензурдаж байв. Нэгэнт цензурын түүхийн тухай өгүүлж байгаа болохоор энэхүү

бурангуй үзэгдэл ямар ямар хэлбэрээр илэрч байсан тухай товч дурдъя.

ХТӨ 399 онд Грекийн суут философич Сократыг үзэл бодлынх нь төлөө шоронд хилс хэргээр хорьж, амия хорлоход хүргэснийг судлаачид цензурын хамгийн харгис хэлбэр гэж үздэг. Тэрээр үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг туштай хамгаалж байсан юм. ХТӨ 213 онд нэгдсэн Хятадын анхны эзэн хаан Цинь Ши Хуан-ди анагаах ухаан, хөдөө аж ахуй, мэргэ төлгө зэрэг шинжлэх ухааны (тэр үед мэргэ төлгийг шинжлэх ухаан гэж үздэг байв) бүхий л ном зохиолыг нилэнхүйд нь устгахыг тушаажээ. Хятадын цагаан хэрмийг бариулсан Цинь Ши Хуан-ди шинэ Хятадыг байгуулах зорилгоор ийм зарлиг буулгасан юм. 499 онд хориотой номын анхны жагсаалт батлагджээ. Пап лам Гелазиус католик шашинтнууд уншиж болохгүй номнуудын нэрс бүхий «Пап ламын индекс» гэгчийг баталсан нь засварлагдан баяжсаар өдгөөг хүрчээ.

1450 онд Йохан Гутенберг хэвлэлийн суурь машин бүтээсэн нь цензор хүрээгээ тэлэхэд дам нөлөө үзүүлсэн юм. 1501 онд шинжлэх ухааны нээлтүүдийг, 1541 онд уран зургийг хүртэл цензурдэж эхэлжээ. Эрх баригчид, шашны томчуул Дундад зууны үед нийгэм, улс төр, иргэний амьдралын бүхий л салбарыг хяналтдаа авч, торгох, хорих, тэр ч байтугай цаазаар авах ялаар шинэ, тэргүүний сэтгэлгээг нухчин дарж

байв. Энэ бүхнээс үзэхэд цензур гэгч нь анхнаасаа харгис агуулга, мөн чанартай арга хэмжээ байсан юм.

Цаг хугацаа улиран одож, нийгэм өөрчлөгдэж байсан ч цензур мөн чанараа хувиргасангүй. Өдгөө цензур гэдгийг албан ёсны институтууд хортой, сөрөг үр дагавартай гэж үзсэн үзэл, мэдээллийн тархалтыг бүрэн хориглох, эсвэл хязгаарлах зорилгоор нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, гаргалт, түгээлт, дамжуулалт, цахим бүтээгдэхүүнийг вэбд байрлуулах төдийгүй, урлагийн бүтээл, захидал харилцаа, цахилгаан мэдээ зэргийг цагдан хянах гэдэг утгаар нь бид ойлгодог. Энэхүү институт нь дэвшилтээ болон харгис хүчин байж болох бөгөөд цензурдэх эрх зүйн чадамжтай байдаг учир албан ёсныд тооцогддог.

Ямар институт цензурыг хэрэгжүүлж буйгаас нь шалтгаалж бид иргэний, цэргийн, эсвэл шашны гэж ангилдаг. Түүнчлэн хамгийн өргөн утгаар нь цензурыг урьдчилсан, дагалдсан буюу цээрлүүлэх гэж хоёр хуваадаг. Урьдчилсан цензур бол аливаа мэдээллийн агуулгыг ОНМХ-ээр түгээхээс өмнө хянаж шалгах, үүний үндсэн дээр зөвшөөрөл олгох ажиллагаа юм. Харин нийтлэл, нэвтрүүлэг олон түмний хүртээл болсных нь дараа тэдгээрийг туурвисан, бэлтгэсэн, түгээсэн хүнд захиргааны шийтгэл хүлээлгэх, эд зүйлийг нь хураах, эрх чөлөөг нь хасах явдал бол дагалдсан цензур билээ.

Хүн төрөлхтөн оршин тогтнож буй бүхий л хугацааныхаа турш цензурын аливаа хэлбэр, илрэлтэй амь хайргүй тэмцээр ирсэн боловч энэхүү сөрөг үзэгдэл одоо ч бидний дунд байна. Дээр бид төрөл бүрийн цензурын илрэлийн тухай өгүүлсэн. Тэгвэл одоо хэвлэлийн цензор дээр тогтох яръя.

Манай улс хэвлэлийн цензурын хамгийн өргөн сүлжээ бүхий хоёр их түрний хооронд оршиж байна. ОХУ, нэн ялангуяа БНХАУ бол аливаа хэлбэрийн цензурээрээ дэлхийд зартай. ОХУ бол манай орны адил нэг талаар маш задгай, негеө талаар маш хатуу цензуртэй өвөрмөц орон юм. Оросод ямар ч хяналтгүй порно сайтууд хамгийн хөгийн гэмээр цензуртэй зэрэгцэн оршиж байна.

Тухайлбал: орон нутгийн «Тульские известия» сонины редактор Александр Меситов ОХУ-ын араанд зуугдсан «ЮКОС» компанийн рекламыг нийтэлснийхээ төлөө ажилгүй болжээ. Түүний оронд урьд нь сэтгүүл зүйд барааны газар ч ойртож байгаагүй дэд хурандаа томилогдсон байна². Приморье «ОТВ-Прим» телесувгийн сэтгүүлч Рушан Янов төрхөм рүүгээ буцжээ. Тэрээр

мужийн амбан захирагчаас ярилцлага авахынхаа өмнө микрофон зүүхдээ түүний пиджакнаас хагийг нь гөвсөн гэж ярьсныхаа төлөө ажилгүй болсон юм. Оросод шууд захирагадалтын бус, эдийн засгийн хэлбэрээр ч цензор хэрэгжиж байна. Энэ нь хүчээр асуудлыг шийдэхээс ч илүү хорон үр дагавартай. Жишээ татахад Томск мужийн цөөн чөлөөт хэвлэлийн нэг «Деловой обзор»

сонин нэгэн дугаартаа мужийн амбан захирагчийн орлогч, «Нэгдсэн Орос орон» эвслийн лидерийг шүүмжилжээ. Шүүх сэтгэл санааны хохирлыг арилгуулах нэрийдлээр 200 мянган рубль гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Сонины эзэнд ийм мөнгө байгаагүй учир арга буюу «Нэгдсэн Орос орон» эвслийн дуу хоолой болжээ³.

«

Урьдчилсан цензур бол аливаа мэдээллийн агуулгыг ОНМХ-ээр түгээхээс омно хянаэж шалгах, үүний үндсэн дээр зовшиорол олгох ажиллагаа юм. Харин шийтгэл, нэвтрүүлэг олон түмший хүртээл болсных нь дараа тэдгээрийг туурвисан, бэлтгэсэн, түгээсн хүнд захирагааны шийтгэл хүлээнгэх, эд зүйлийг нь хураах, эрх чоюог нь хасах явдал бол дагалдсан цензур билээ.

»

БНХАУ-д урьдчилсан ба дагалдсан цензурын аль аль нь маш хүчтэй. Сүүлийн жилүүдэд Хятад интернет хэмээн даяар сүлжээг өөрийн нутаг дэвсгэр дээр хяналтдаа авах зорилгоор маш олон шийдвэр, захирамж гаргаж байна. Хамгийн сүүлийн жишээ бол Хунан мужийн «Contemporary Business News» цахим сонины сурвалжлагч 37 настай

Ши Тао гадаадын веб-сайтуудад улсын нууц мэдээлэл задруулсан хэргээр 10 жилээр яллагдсаныг дэлхийн олон нийт буруушааж байгаа юм⁴. Билл Гейтс энэ талаар: «Интернетийг цензурдэх гэсэн аливаа оролдлого анхнаасаа нуран унах тавилантай» гэсэн байдал. MSN порталаын хятад хувилбар дээр ардчилал, эрх чөлөө, хүний эрх, Тайваний эрх чөлөө, жагсаал цуглаан зэрэг үг хэрэглэхийг БНХАУ-ын засгийн газрын шаардлага, шахалтаар хориглосон аж⁵.

X оёр хөршийнхөө тухай өгүүлсний дараа өөрийн орны ганц хоёр жишээ дурдах гэсэн юм. Ардчилсан хүмүүнлиг гэгдэг манай нийгэмд социалист Хятадын адил урьдчилсан ба дагалдсан цензур сүртэй ч, хүчтэй ч байна. 1996 онд «Ардчилсан холбоо» эвсэл засгийн эрхэнд гарангутаа чөлөөт хэвлэлүүдийг хаах ажиллагааг эхлүүлсэн, 2000 онд МАХН энэ уламжлалыг үргэлжлүүлсэн, бичсэн нийтлэлийнхөө төлөө сэтгүүлчид шүүхэд дуудагдах, ял зэмлэл хүлээх нь aanай л цензур билээ. ХМХ эрхлэн гаргахыг хүссэн хүн заавал ХЗДХЯ-д бүртгүүлдэг, дээр нь бас сэтгүүлчийн мэргэжилтэй хүн заавал ажиллахыг шаардах явдлыг олон улсын жишгээр цензурын нэг хэлбэр гэж үздэг.

Хэдийгээр 1998 онд батлагдсан «Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай» хуульд цензурын аливаа хэлбэрийг устгасан тухай тунхагласан ч үнэн

хэрэгтээ бодит байдал тэс өөр байна. Хэвлэл эзэнтэй байгаа цагт хэзээ ч чөлөөт байж чадахгүй гэж ярьдаг нь үнэний хувьтай юм. Ийм нөхцөлд сэтгүүлчид алхам тутамдаа цензурын илрэлтэй тулгарч байна. Энэхүү цензур манайд нийтлэлийн бодлого гэдэг ойлголтоор илэрдэг. Сонирхолтой нь сэтгүүлчид төдийгүй, дадлагын оюутнууд ч нийтлэлийн бодлого гэдэг Берлины ханыг мөргөж, хүч мөхөсддөг. Дадлагын тайлангаа хамгаалж буй зарим оюутнаасаа яагаад аахар шаахар мэдээнээс өөр зүйл бичээгүй юм бэ гэж асуухад дорвигийнхон юм бичих гэхээр манай сонины нийтлэлийн бодлогод тохирогчийг гээд өр болохгүй юм гэж учирладаг. Яг ийм нийтлэлийн бодлогоос болж манай нэрт сэтгүүлч, Соёлын гавьяат зүтгэлтэн Б.-Лигдэн гуай ажлаа солихоос өөр аргагүйд хүрснийг⁶ бодвол дадлагын оюутнуудыг ойлгоход тийм ч түвэгтэй биш.

Энэ бол мөсөн уулын өрдөө л орой юм. Сонины редакци бүр доор доороо бяцхан Главлит болчихоод байна. Юуг нийтлэх вэ, харин юуг эс нийтлэх вэ гэдгийг тэрхүү «Главлит» шийдэж байна. Бид энэ маягаараа бол нэг алхаад хойд хөршийнхөө, тэндээсээ ганц том харайгаад урд хөршийнхөө зиндаанд очих нь.

Илтгэлийнхээ эцэст би нэг санал дэвшүүлэх гэсэн юм. Энэ бол Монгол дахь цензурын аливаа хэлбэрийг тодорхой жишээ баримттай гаргах зорилгоор тусгай веб сайт ажиллуулах юм. Мэр-

гэжлийнхээ үйл ажиллагааг гүйцэтгэж явахдаа цензуртэй тулгарсан сэтгүүлч энэхүү сайт руу ороод өөрт тохиолдсон явдлын тухай бичих юм. Улмаар бид цензур Монголд ямар төвшинд хүрчихээд байгаа, үзэл бодлоо илэрхийлэх, уг хэлэх болон хэвлэн нийтлэх, мөн мэдэх эрхэд ямар аюул заналхийлж байгаа талаар үнэн бодитой, ул суурьтай мэдээлэл авч болно.

Ишлэл

¹ <http://www.washprofile.org/SUBJECTS-2/censor.html>

² «Независимая газета». 2006.01.15.

³ Там же.

⁴ <http://net.compulenta.ru/226433/>

⁵ <http://net.compulenta.ru>

⁶ Гантуг Д., Энхтуяа Ч. 1999. Хэвлэл яагаад шарладаг вэ? Эрх чөлөө нь дутагдал... УБ., 12 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

¹ Гантуг Д., Энхтуяа Ч. 1999. Хэвлэл яагаад шарладаг вэ? Эрх чөлөө нь дутагдал... УБ.

² Зулькафиль М. 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.

³ Менчер М. 2002. Сэтгүүл зүйн бичлэгийн үндэс. УБ.

⁴ Багерстам Э. 1992. Свобода прессы в демократическом обществе: настольная книга по этике прессы. Тарту.

⁵ Федотова Л. Н. 1996. Массовая информация: стратегия производства и тактика потребления. М.

Резюме

В данной статье автор рассматривает сущность, проявление и негативные последствия цензуры печатных производств. В нашей стране, несмотря на то, что в 1998 году Законом о свободе массовой информации была официально упразднена цензура, до сих пор встречаются случаи, когда должностное лицо, социальный институт и даже частное лицо пытается подвергнуть цензуре продукцию СМИ. Однако самым настораживающим фактом является осуществление цензуры внутри самой редакции или студии СМИ, вследствие чего возникает самоцензура журналистов.